

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ОРОН НУТГИЙН ХУРЛЫГ ТАРААХ ҮНДЭСЛЭЛ, ЖУРАМ

(Мэдээлэл, лавлагаа)

Д.Халиун, Г.Билгээ
Д.Жигваагүнсэл, О.Нарантуяа

	<i>Польш</i>	<i>Словени</i>	<i>Унгар</i>	<i>Финланд</i>
Үндэслэл	<p>Үндсэн хууль²³⁰</p> <p>171.3.Хэрэв орон нутгийн өөрөө удирдах Үндсэн хуулийн байгууллага нь <u>Үндсэн хууль, бусад хуулийг ноцтой зөрчвөл</u> ... Сейм түүнийг тарааж болно.</p>	<p>Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын хууль²³¹</p> <p>90b. - хэрэв зөвлөл нь Үндсэн хууль зөрчсөн хууль баталсан, эрх бүхий шүүхээс гаргасан шийдвэрийг биелүүлээгүй, энэ хуулиар тогтоосон чиг үүргээ биелүүлээгүй, хууль тогтоомж зөрчсөн шийдвэр гаргасан, яамнаас анхааруулсан боловч хууль бус үйлдлээ засаж чадаагүй бол;</p> <p>- хэрэв зөвлөл нь хуульд заасан хугацаанд төсвөө батлаагүй бол;</p> <p>- хэрэв орон нутгийн зөвлөл нь хагас жилд 3 удаа хуралдуулахаар зарласан боловч хуралдаагүй бол.</p>	<p>Үндсэн хууль²³²</p> <p>35.4.Төлөөлөгчдийн байгууллага нь <u>кардинал хуульд заасны дагуу</u> өөрөө тарах тухайгаа зарлаж болно.</p> <p>35.5....Үндэсний Ассамблей нь Төлөөлөгчдийн байгууллагыг <u>Үндсэн хууль зөрчсөн гэж үзвэл</u> тарааж болно.</p>	-
Санаачлах эрх бүхий субъект	<p>Үндсэн хууль</p> <p>171.3.Хэрэв орон нутгийн өөрөө удирдах Үндсэн хуулийн байгууллага нь ... <u>Ерөнхий сайдын өргөдлийг үндэслэж Сейм</u> түүнийг тарааж болно.</p>	<p>Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын хууль</p> <p>90b. Орон нутгийн зөвлөлийг Засгийн газрын саналыг үндэслэн Үндэсний Ассамблей тарааж болно.</p>	<p>Үндсэн хууль</p> <p>35.5.<u>Засгийн газрын саналаар</u> Үндсэн хуулийн шүүхийн саналыг авсны дараа Үндэсний Ассамблей нь Төлөөлөгчдийн байгууллагыг ... тарааж болно.</p>	-

²³⁰https://www.constituteproject.org/constitution/Poland_2009?lang=en

²³¹The law on local self-government <http://unpan1.un.org/intradoc/groups/public/documents/UNTC/UNPAN015730.pdf>

²³²Constitution of Hungary 2011 (rev. 2016). www.constituteproject.org/constitution/Hungary_2016?lang=en

Батлах саналын хувь	<p>120. Үндсэн хуульд илүү тооны саналаар батална гэж заагаагүй бол Сейм хуулийг <u>Сеймийн гишүүдийн хуулиар тогтоосон тооны тал хувиас доошгүй ирцтэй хуралдааны өрдийн олонхын саналаар батална. ... тогтоолыг мөн адил журмаар батална.</u></p>	<p>Үндсэн хууль²³³</p> <p>86. Үндэсний Ассамблейн хуралдаанд гишүүдийн олонх нь хүрэлцэн ирснээр шийдвэр гаргах эрхтэй болно. Үндсэн хууль болон бусад хуульд өөрөөр заагаагүй бол хууль болон бусад шийдвэрийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.</p>	<p>Үндсэн хууль</p> <p>5.5. Үндэсний Ассамблейн хуралдаанд гишүүдийн олонх нь хүрэлцэн ирснээр шийдвэр гаргах эрхтэй болно.</p> <p>5.6. Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Үндэсний Ассамблейн хуралдаанд оролцсон гишүүдийн <u>талаас дээш хувийн саналаар</u> асуудлыг шийдвэрлэнэ. Үндэсний Ассамблейн дэгийн тухай хуулиар тодорхой асуудлыг шийдвэрлэхэд хангалттай олонхын саналыг шаардаж болно.</p> <p>Судалгаагаар Өөрөө тарах тухай асуудлыг орон нутгийн Төлөөлөгчдийн байгууллагын олонхын саналаар шийдвэрлэнэ.²³⁴</p>	-
---------------------	--	---	--	---

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

²³³Constitution of Slovenia https://www.constituteproject.org/constitution/Slovenia_2016?lang=en

²³⁴Local Self-Governance in the Member States of European Union: Local Self-Government in Hungary. 2014. 24 дэх тал. http://real.mtak.hu/31805/1/mono_hungary_en_2014.pdf